

“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ
2024-03-25

№	Компанийн засаглалын үндсэн зарчим	Үнэлгээний асуулга	Хэрэгжилт	
			оноо	хувь
1	ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнгэй бүтэц байна	12	100
2	ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ	ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ	10	100
3	ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана	6	100
4	АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО	ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнгэй байдлыг хангана	6	100
5	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнгэй байдалд тогтмол хяналт тавина	6	75
6	ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна	5	83.3
7	АШИГ	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ	6	75
8	КОМПАНИЙН СОЁЛ	ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно	6	100
9	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ	Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана	10	100
нийт үнэлгээ			67	92.60%

**“УЛААНБААТАР БҮК”ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЙЛАН**

2024 он

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь%/
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	<i>ТУЗ-нь ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна. /Компанийн сайтад/</i>	<i>ТУЗ-ийн №2022/18 тогтоол</i>	2	100
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	<i>ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын бичиг баримтыг шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна</i>	<i>ТУЗ-ийн №2022/18 тогтоол</i>	2	100
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	<i>ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг Компанийн болон ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулж ажиллаж байна.</i>	<i>2023 оны жилийн эцсийн тайлан</i>	2	100
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	<i>Компанийн дүрэм, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын журамд тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн, гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага зэргийг тусгаж ажилладаг.</i>	<i>Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж ТУЗ-өөр батлуулан мөрдөн ажиллаж байна.</i>	2	100
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	<i>Сүүлийн 5 жилийн байдлаар нийт 17 нэр дэвшигчийг Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулж ТУЗ-ийн гишүүнээр ХЭХ-аар хэлэлцүүлж томилж ажилласан ба сонгогдсон гишүүд бүгд засаглалын сургалтад хамрагдсан болно. Мөн түүнчлэн СЗХ, МХБ, Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Дотоод аудиторын институтээс зохион байгуулсан Засаглалын талаарх сургалт семинарт тогтмол хамрагдсан. ХК-иудын тайлагналыг оновчтой болгох зорилгоор зохион байгуулсан олон улсын “Арам” төслийн цогц сургалтанд ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, Аудитын хорооны дарга зэрэг эрх бүхий албан тушаалтнууд хамрагдаж гэрчилгээ авсан.</i>		2	100

6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь түүний эрх үүрэг, хариуцлага зэргийг тодорхой тусгасан “ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам”, ТУЗ-ийг төлөөлж ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээний дагуу ажилладаг ба эдгээр бичиг баримтад Нарийн бичгийн даргын хүлээх хариуцлагын талаар тодорхой тусгасан болно. /Компанийн сайтад/		2	100
ДҮН				12	100
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	ТУЗ-ийн 6 гишүүн ердийн гишүүний 3-нь хараат бус гишүүнээр ажиллаж байгаа ба хороодын дарга нарыг Хараат бус гишүүдээр томилсон.		2	100
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Аудитын хороо нь үйл ажиллагааны журам болон “Улаанбаатар БҮК”ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах, ажлын чанарыг хянах журам”-ыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг. /Компанийн сайтад/ Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус хараат бус гишүүн/ Хорооны дарга хараат бус гишүүн С.Б.Громов/ ба Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд тус хорооны хүсэлтээр оролцдог.	Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж ТУЗ-ийн ээлжит хуралд оруулж батлуулсан.	2	100
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журамтай/Компанийн сайтад/ ба цалин урамшууллын бодлогын баримт бичгийг баталж 2022 оны 5 сарын 19-нд ТУЗ-ийн хуралд танилцуулсан. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүнээр/хараат бус гишүүн Г.Цогнэмэх/ ажилладаг. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага хорооны хүсэлтээр оролцож байна.	Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулсан ба 2023 онд ТУЗ-ийн ээлжит хуралд оруулж батлуулсан болно.	2	100
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журамтай/Компанийн сайтад/ ба залгамж халааны бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн ажиллаж байна. /Хорооны дарга хараат бус гишүүн Ч.Энхбат/	ТУЗ-ийн №2022/18 тогтоол	2	100
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай	ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй ажилладаг.	ТУЗ-ийн гишүүдийн судалгаа	2	100

	мэдлэг, ур чадвар, ажлын туриллага бүхий бүрэлдэхүүнтэй байна.				
ДҮН			10	100	
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж/Компанийн сайтад/хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна. МХБ-ийн сайтад хууль, журмын дагуу 5 багц мэдээллийг 11 төрлийн маягтын дагуу улирал, хагас жилээр байршуулан нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллаж байна.	Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж ТУЗ-өөр батлуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2	100
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг ТУЗ –нь Компанийнхаа цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэж ажилладаг.		2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, түүний тэнцвэртэй, тодорхой, бодит байдал, хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхэд жилд 2 удаа хөндлөнгийн аудитын байгууллагаар хяналтыг хийлгэж, /МХБ, Компанийн сайт/ өгсөн зөвлөмжийг тухай бүр ТУЗ-аар хэлэлцүүлэн Гүйцэтгэх удирдлагад тодорхой үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг биелүүлж ажилладаг.	Хөндлөнгийн аудитын тайланг цаг хугацаанд нь хөрөнгийн биржийн сайтад байршуулсан	2	100
ДҮН				6	100
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Аудитын хорооны үйл ажиллагааны журам болон “Улаанбаатар БҮК”ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах,ажлын чанарыг хянах журам”-д хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтийг гэрээний үндсэн дээр хянаж ажилладаг.	2 талын гэрээнд одоогоор зөрчил гараагүй байна.	2	100
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгч ажилладаг. 2022 оны ээлжит ХЭХ-д “Грант торнтон” ХХК-ийн ахлах аудитор Батхишиг оролцож хувьцаа эзэмшигчдэд холбогдох мэдээлэл, тайлбар хийсэн.		2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон	Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх	ТУЗ-ийн шийдвэрээр Аудитын	2	100

	өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	мэдээллийг компанийн үйл ажиллагааны улирал бүрийн тайланд тусган ХБ-ээр дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлж ажилладаг. /МХБ/	хорооны ажлын алба байгуулж, 1 дотоод аудиторыг томилон ажиллуулж байна.		
ДҮН				6	100
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Компани эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд хяналт тавьж ажиллах зорилгоор ТУЗ – ийн шийдвэрээр 2022 онд ISO нэвтрүүлэх өргөн цар хүрээтэй ажлыг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөтэйгээр эхлүүлж 2023 онд гэрчилгээ авсан.		2	100
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	ТУЗ 2023 онд Аудитын хороонд эрсдэлийн хорооны чиг үүргийг хавсарган үйл ажиллагааар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Аудит эрсдэлийн хорооны журам, Эрсдэлийн удирдлагын бодлогыг ТУЗ баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		2	100
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.				
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Комплайнсын хяналтын заавар болон бүтэц, хяналтын журмыг 2023 онд ТУЗ баталсан.	Компанийн сайтад мэдээллийг байршуулсан.	2	100
ДҮН				6	75
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, төсвийг 2023-4-20-ны өдрийн хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэж баталсан./ХЭХ-ын тогтоол, МХБ болон Компанийн сайт/		2	100
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгасан цалин, урамшууллын бодлогын баримтыг Цалин хөлсний хороогоор 2022-4-29-ний өдөр оруулан		2	100

		хэлэлцсэн ба энэхүү бодлогын бичиг баримтын хүрээнд 2 журам боловсруулагдаад байна. 2023 онд “ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий алын тушаалтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам” баталж, 2023 оны үйл ажиллагааг дүгнэсэн болно.			
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг ТУЗ-тэй байгуулсан гэрээнд тусган ажиллаж байна.		1	50
ДҮН				5	83,3
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Компани нь бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичиг боловсруулж бэлтгэсэн.		2	100
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.				
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор CRM HABSPOT цахим сүвгийн дагуу авсан сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн харилцагч байгууллагын тоог нэмэх, бүтээгдэхүүний чанарт анхаарах, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх асуудлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж ажилладаг ба хэрэглэгчийн сэтгэл ханамж 79,8% түвшинд байна.		2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх талаар дотоод журамдаа тусган ажилласнаар сар бүр дундаар 20 ажилтнуудын нийгмийн асуудлыг амаар болон бичгээр тайлбарлан шийдвэрлэн ажилласан байна.		2	100
ДҮН				6	75
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд	Хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор Компанийн үнэт зүйлс, алсын харааг жил бүрийн бизнес төлөвлөгөөнд оновчтой тодорхойлж ажилладаг ба ТУЗ нь ёс зүйн	Мэдээллийг Компанийн сайтад тавьсан.	2	100

	мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	дүрмийг ТУЗ-өөр 2023 онд батлуулан мөрдөн ажиллаж байна.			
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг арилгуулах зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдлийн хороонд хороонд "Дотоод аудитын нэгж" байгуулсан.		2	100
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	ТУЗ-өөр батлах "Ёс зүйн дүрэм"-д авлигла, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулалтыг оруулж "Ёс зүйн дүрэм"-ийг баталсан.		2	100
ДҮН				6	100
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Компани үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх тайлан, мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэж ажиллаж байна.		2	100
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.				
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа ба мэдээлэл хүссэн хувьцаа эзэмшигч иргэнд биечлэн, утсаар, цахим хаягаар хандаж тухай бүр мэдээллийг өгч ажиллаж байна.		2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь анхаарал хандуулан тодорхой мэдээллийг үндэслэлтэй өгөх, үйлдвэрийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцуулах зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.		2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баталж мөрдөж ажиллаж байгаа ба энэ тухай тогтоол шийдвэрийг хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд мэдээлэх замаар хэрэгжүүлж ажиллаж байна.		2	100
ДҮН				10	100
НЭГДСЭН ДҮН				67	92,6

-оОо-